



“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК

Тендер шалгаруулалт  
гэрээний нэр:

**АККУМУЛЯТОР НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОХ ТЕНДЕР  
ШАЛГАРУУЛАЛТ**

Тендер шалгаруулалт

гэрээний дугаар:

**ЭТТ/202001116**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020 оны 08 дугаар сарын 04-ний өдөр

**“Эрдэнэс-Тавантолгой” ХК** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Аккумулятор** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг **2020 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 10 цаг 00** минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 10 цаг 30** минутад нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх: **Үгүй**

Сонирхсон этгээд тендертэй холбоотой бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8,  
Финанс төв, 5 давхар 503 тоот  
Утас: +976-7505-5555-511

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 1 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан.</li> <li>2. 2018, 2019 оны аль нэг жилд ижил төстэй аккумулятор нийлүүлж байсан туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн 1-ээс доошгүй ажлын гэрээний хуулбарыг хүлээлцэх актын хамт ирүүлэх/.</li> <li>3. Компанийн танилцуулга.</li> <li>4. Компанийн гэрчилгээний хуулбар.</li> <li>5. Татварын тодорхойлолт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-д тендер нээх өдрийн байдлаар өртэй болон дутуу төлөлтгүй байх.</li> <li>6. Шүүхийн төрөлжсөн архивын газрын тодорхойлолт ирүүлэх. /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/</li> <li>7. ШШГЕГ-ын тодорхойлолт. /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/</li> <li>8. Тендерт шалгарсан тохиолдолд техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй бараа нийлүүлвэл захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан бичиг ирүүлэх.</li> <li>9. Тендерт шалгарсан тохиолдолд тендерт санал болгосон хугацаандаа нийлүүлээгүй бол захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан бичиг ирүүлэх.</li> <li>10. Техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтийг хангасныг нотлох баримт ирүүлэх.</li> <li>11. Техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэх бараа бүтээгдэхүүний зургыг болон иж бүрдлийг хүснэгтлэн жагсааж ирүүлэх.</li> <li>12. Нийлүүлэгч нь нийлүүлэх аккумуляторт 1 жилийн чанарын баталгаа өгөх.</li> </ol> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай эсэх: <b>Үйлдвэрлэгчээс өгсөн худалдан борлуулах албан ёсны эрхтэй байх. /Нотлох баримт бичгийг ирүүлэх/</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Хаяг: <b>Цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр /pdf/-ээр илгээнэ.</b></p> <p>Огноо: 2020 оны 08 дугаар сарын 13-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв, Утас: +976-7505-5555-511</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 5 давхар 503 тоот</p> <p>Огноо: 2020 оны 08 дугаар сарын 13-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минутад нээнэ.</p>
ТӨӨЗ 6.2	<ol style="list-style-type: none"> <li>1. Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй</b></li> </ol>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Салбар уурхайд нийлүүлэх аккумуляторын техникийн тодорхойлолт

#### Үндсэн шаардлага:

- ✓ Захиалагчид нийлүүлэх аккумулятор нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан үзүүлэлтээс зөрөөгүй байна.
- ✓ Барааг үйлдвэрлэгч компани нь олон улсад болон Монгол улсад танигдсан чанартай, найдвартай бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компани байна.
- ✓ Бараа нийлүүлэгч нь нийлүүлсэн аккумуляторт чанарын баталгаа ирүүлнэ.
- ✓ Хавсралт 2-т заагдсан аккумуляторыг захиалагчийн гаргасан захиалгын, тоо ширхэгт үндэслэн гүйцэтгэлээр нийлүүлэгдэнэ.
- ✓ Хавсралт 2-т тусгагдаагүй хүчин чадалтай аккумулятор худалдан авах шаардлага үүссэн тохиолдолд захиалагчийн хүсэлтээр шаардлагатай аккумуляторын жагсаалтыг гарган гэрээнд (хавсралт 3,4 г.м) нэмэлт өөрчлөлт оруулах ба нийлүүлэгч компани тухайн аккумуляторыг зах зээлийн дундаж ханшаар нийлүүлнэ.

№	ТЕХНИКИЙН МАРК	ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
1	Аккумуляторын техникийн тодорхойлолт	Хавсралт 1
2	Аккумуляторын тоо, хэмжээ	Хавсралт 2

#### Хавсралт№1

ЗОРИУЛАЛТ:		ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:	
1.1		Хяналтын гидрометртэй байх	
		Гадна гэр /лацадсан таглаа/ шингэн алдалт, бохирдолд, бат бөх хамгаалалттай байна.	
		Дөл үсрэхээс сэргийлсэн дөл сааруулагчтай байна.	
		Гадна хайрцаг чичрэлт, замын донсолгооноос үүсэх аккумуляторын элементийг эвдрэхээс хамгаалсан хамгаалалттай байх	
1.2	Үндсэн үзүүлэлт	<b>Аккумуляторын хүчин чадал</b>	<b>Зориулалт</b>
		12V 60 ам/цаг-ийн хүчин чадалтай	HIMOINSA, INGERSOLL RAND маркийн Зөөврийн гэрэлт цамхагт
		12V 90 ам/цаг-ийн хүчин чадалтай, баруун болон зүүн шонгийн байрлалтай	LC-70 Серийн автомашинд ашиглагдана.
		12V, 120 ам/цаг-ийн хүчин чадалтай том оврын, ачаа тээврийн автомашинд зориулагдсан удаан эдэлгээтэй байна.	NISSAN UD маркийн 20 тн-ын автоцистернд ашиглагдана.
		12V, 200 ам/цаг-ийн хүчин чадалтай том оврын, ачаа тээврийн автомашинд	КАМАЗ маркийн ачааны зориулалттай автомашинд ашиглагдана.


		зориулагдсан удаан эдэлгээтэй байна.
1.3	Ашиглалтын нөхцөл	ОХУ, Япон улсад үйлдвэрлэгдсэн тухайн орны стандартыг хангасан ашиглалтын хугацаа 1 жил болон түүнээс дээш, 2020 оноос хойш үйлдвэрлэгдсэн байна. -40°C-аас +40°C хэмийн нөхцөлд хэвийн ажиллахаар хийгдсэн байна.

## Хавсралт-2

### ТОО, ХЭМЖЭЭ, ХҮЧИН ЧАДАЛ

№	Аккумуляторын хүчин чадал	Тоо, хэмжээ	Техникийн тодорхойлолт
1	60А	8ш	L, R Байрлалын шонтой байна.
2	90А	70ш	L, R Байрлалын шонтой байна
3	120А	10ш	L, R Байрлалын шонтой байна
4	200А	4ш	L, R Байрлалын шонтой байна

### “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төв оффист нийлүүлэх аккумуляторын техникийн тодорхойлолт

№	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо	Зориулалт	Техникийн тодорхойлолт
1	Аккумулятор	ш	7	Албан ажлын хэрэгцээнд	 <p>Solite –тэй дүйцэхүйц 70А –ийн аккумулятор 5 ш 90А –ийн аккумулятор 2 ш</p>

- 1. Барааны тодорхойлолт:** [Барааны тодорхойлолт, техникийн үзүүлэлтийг энд бичнэ.]
- 2. Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
- 3. Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
- 4. Бараа хүргэх газар:** “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн агуулахад

5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхой лолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Аккумулятор	Техникийн тодорхойлолтод заасны дагуу	Техникийн тодорхойлолтод заасан тоо хэмжээгээр	Техникийн тодорхойлолтод заасны дагуу	“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн агуулахад	<i>Гэрээ байгуулагдсанаас хойш 14 хоногийн дотор</i>	<i>Гэрээ байгуулагдсанаас хойш 20 хоногийн дотор</i>	



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[моо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан моо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1)                             | 1.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлд заасны дагуу барааг хүлээн авах үед Захиалагч талаас томилсон эрх бүхий этгээд барааг шалгаж хүлээн авна. Барааг шалгахтай холбоотой бүхий л зардлыг Гүйцэтгэгч тал хариуцна.  |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br><br>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.                                      |
| 3. Төлбөр (ГЕН – 7)  | 4.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br>Гэрээнд заасан барааг Захиалагчаас өгсөн захиалгын дагуу гүйцэтгэлээр нийлүүлэх бөгөөд нийлүүлсэн болохыг нотолсон барааг хүлээн авсан акт, нэхэмжлэх болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн ажлын 60 хоногийн дотор гүйцэтгэлээр нийлүүлэгч талд бүрэн төлнө. |
| 4. Алданги оногдуулах (ГЕН - 9) <sup>1</sup>                 | 6.1. Алданги ноогдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн <b>[0.5%]</b> байна<br><br>Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн <b>[10 хувь]</b> байна.  |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*